



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 513 дугаар тогтоолын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 607 дугаар тогтоолд заасан хөдлөх хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч,  
Төрийн өмчийн төлөөлөгч:

Д.Батболд  
Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын  
хэлтсийн мэргэжилтэн

Дуудлагын худалдааны хөтлөгч:

Б.Мөнхбаатар  
Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын  
хэлтсийн ахлах мэргэжилтэн


Дуудлагын худалдааны тэмдэглэл  
хөтлөгч

Д.Эрдэнэбаяр  
Аймаг дундын отрын бэлчээр  
ашиглалтын захиргааны хууль, эрх  
зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах, үр дүнг 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдөрт багтааж танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Батболд)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ



ТӨБЗГ тушаал-/2023

132003107